



193 Page



194 Page



195 Page



196 Page

Хааны хатан Естер

- Queen Esther -

Тайлбарлагч Хааны хатан болох хүнийг сонгох тухай зар бүх нутаг даяар таржээ. Гоёж чимэглэсэн охид хааны ордон уруу ирцгээж байлаа. Ордонд ажилладаг Мордехаид Естер гэдэг үеэл охин дүү байжээ. Естер маш үзэсгэлэнтэй нэгэн байжээ. Түүний аав ээж нь багад нь өнгөрсөн болохоор Мордехаи түүнийг өөрийн охин шиг өсгөжээ.

Мордехаи Естер дүү минь, хаан өөрийн хатан болох хүнээ сонгох гэж байна. Би чамайг хааны хатан болоход тохиромжтой гэж бодож байна. Чи хаанд таалагдах байх. Гэхдээ Израиль эмэгтэй гэдгээ хэлж болохгүй шүү. Ойлгосон уу?

Түшмэл "Нэг нэгээрээ хааны өмнө ирнэ үү"

Тайлбарлагч Маш гоё хувцасласан охид хааны өмнө ирцгээв. Гэнэт хааны нүд гэрэлтэж эхлэв.

Хаан "Тэр үнэхээр хайр хүрэм, үзэсгэлэнтэй бүсгүй байна"

Хүмүүс Шинэ хатан тодорлоо!!

Тайлбарлагч Хаан маш олон охидоос Естериийг сонгожээ. Тэгээд түүнд эрдэнийн шигтгээтэй титэм зүүлгэв. Ингээд Естер хааны хатан болж, Хаман гэдэг хүн сайд болжээ.

Хаан "Бүгд Хаманд өвдөг сөгдөн, хүндэтгэл үзүүл!"

Хүмүүс "Хаман сайд мандтугай!"

Тайлбарлагч Хаман өөрт нь сөгдөж байгаа хүмүүсийг хараад, ихэд тааламжтай байв.

Хаман (сэтгэл дотроо) "Би үнэхээр мундаг хүн юм даа. Энэ улсад надаас илүү мундаг хүн байна уу!"

Тайлбарлагч Гэтэл Хаманд огт сөгдөөгүй нэг хүн байлаа. Тэр хүн бол Естериийг өсгөсөн Мордехаи байжээ.

Мордехаи Бурханаас өөр хэний ч өмнө сөгдөн хүндлэхгүй гэхэд Хаман маш их уурлав.

Хамаан "Энэ одоо юу вэ? Намайг хүндлэн, миний өмнө сөгдөхгүй байж зүрхэлнэ гэнэ ээ? Энэ муу Мордехайг яаж чадах вэ байз!"

Тайлбарлагч Хаман, Мордехаиг Бурханыг хүндлэдэг Израиль хүн гэдгийг нь мэдчихжээ. Тэгээд тэр нэгэн хорон төлөвлөгөөг бодож олов.

Хаман "Хаантан минь, эх оронд минь хааны хуулийг зөрчдөг нэгэн сонин үндэстэн байна."

Хаан "Юу? Тийм үндэстэн байна гэнээ?"

Хаман "Хаантанд хор хөнөөл учруулж магадгүй учир тэднийг хөнөөх хэрэгтэй"

Хаан "Хмм...тийм шүү, тэднийг устга."

Тайлбарлагч Хаман хааны зарлигийг бүх нутаг даяар тараажээ.



197 Page



198 Page



199 Page

Хаман “Манай улсад амьдардаг Израиль үндэстнийг дураараа алж тэдний хөрөнгийг авч болно.”

Тайлбарлагч Үүнийг сонсоод Израильчууд ихэд сандран, хоол ч идэлгүй Бурханы өмнө хувцасаа уран гунигтайгаар уйлцгаажээ. Мордехай ч мөн адил хааны ордны хаалганы дэргэд суугаад уйлжээ.

Естер “Израильчууд яагаад гунигтайгаар уйлж байгаа шалтгааныг Мордехай ахаас асуугаад ир.”

Шивэгчин За...хатан минь, хатан минь! Айхтар хэцүү зүйл болжээ. Израиль хүмүүсийг хөнөөх тушаал гарсан байна. Хаанаас амь аврах тухай гуйх хэрэгтэй гэж Мордехай хэллээ

Естер Тийм үү, одоо яадаг билээ!

Тайлбарлагч Үүнээс болоод хатан Естер ихэд цочирджээ. Хааны өмнө очихоос айсан Естер маш их санаа зовон, Мордехай уруу өөрийн шивэгчинээ дахин явуулжээ.

Мордехай Хааны хатан болсон шалтгаан нь ийм аюултай үеийн төлөө юм гэж дамжуулж өгнө үү.

Шивэгчин Тэгэж хэлсэн

Естер “Израильчуудад гурав хоногийн турш юу ч идэлгүй мацаг барин миний төлөө залбираарай гэж дамжуулж өгнө үү. Би ч бас юу ч идэлгүй залбирч, үхэх аюултай байсан ч хамаагүй хаанд очиж заавал хэлэх болно.

Тайлбарлагч Гурав хоногийн дараа, Естер хааны өмнө очжээ. Хаан түүнийг хараад баярлав.

Хаан Естер, ямар хэргээр ирэв? Чи хүсвэл хаант улсынхаа талыг өгөхөд ч бэлэн байна.

Естер “Хаантан минь, би найр бэлдсэн тул, та Хамантай цуг ирнэ үү”

Тайлбарлагч Хатан өөрийг нь найранд урьсныг сонсоод Хаман бүр илүү бардам болжээ. Хаан Естерийн бэлдсэн найранд сэтгэл нь хөдөлж, хатнаас хүслийг нь асуув. Тэгэхэд Естер хаанд хандан:

Естер “Хаантан минь, би болон миний үндэстэн нэг. Миний ард түмний амийг авраач”

Хаан “Юу гэнээ? Хэн миний хатныг алах гэж оролдов?”

Естер “Тэр хүн бол Хаман.”

Хаман Үгүй, үгүй. Би биш хаантан минь. Естер хатан минь, Амь өршөө! Хаантан минь.

Хаан “Энэ Хаман, хатныг гүтгэнэ гэнээ. Энэ хүн үнэхээр бардам болжээ! !”

Тайлбарлагч Эцэст нь Хаман Мордехайг дүүжилж алах гэж бэлдсэн өнөөх дүүжлүүр дээрээ өөрөө дүүжлүүлэн үхэв.

Хаан олон жилийн өмнө миний амийг аварсан хүн бол Мордехай юм байна гэдгийг мэджээ. Тэгээд Мордехайг сайдаар томилов. Мөн Естер хаанд дахин нэг хүслээ хэлжээ.



200 Page

Естер

“Израиль хүмүүсийг алж болно гэсэн тушаалаа хүчингүй болгож өгөөч”

Тайлбарлагч

Хаан, Естериин хүслийг ёсоор болгожээ. Израильчуудаас нэг ч хүн үхсэнгүй. Ийнхүү Естер хатан, Бурханд найдан залбирч, маш их зориг гарган хаантай уулзаж, өөрийн үндэстнээ аварч чадсан юмсанжээ.